



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/125

Мандалговь

Г Хот тохижуулах газрын бүтэц орон тоог
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "в" заалт, Төсвийн тухай хуулийн 65.1.8 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчын хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 65 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мандалговь хотын Захирагчийн эрхэлсэн асуудлын хүрээнд Хот тохижуулах газрын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн баталсугай.

Хоёр. Хот тохижуулах газрын 2018 оны төсөвийг хавсралт-1 –ээр баталсугай.

Гурав. Хот тохижуулах газрын бүтэц орон тоог хавсралт-2 –оор баталсугай.

Дөрөв. Хот тохижуулах газрын үйл ажиллагааны чиглэл, ажиллах дотоод журам, албан хаагчдын ажлын чиг үүргийн хуваарийг боловсруулж баталж, хяналт тавьж ажиллахыг Мандалговь хотын захирагч /Р.Мөнхтогтох/-д үүрэг болгосугай.

Тав. Энэ шийдвэр гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/483 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200444

Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 465 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

Дундговь аймгийн Хот тохижуулах газар
2018 оны ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ



мянган төгрөгөөр

Код	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны төсвийн төсөл
71502	Хот байгуулалт, тохижилт	251,411.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	22,802.5
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,802.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,802.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,802.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,868.5
210101	үндсэн цалин	15,418.4
210102	Нэмэгдэл	1,450.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	
210105	Гэрээт ажлын хөлс	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,024.2
210201	Тэтгэврийн даатгал	1,349.5
210202	Тэтгэмжийн даатгал	134.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	168.7
210204	Ажилгүйдлийн даатгал	33.7
210205	Эрүүл мэндийн даатгал	337.4
2104	Хангамж, бараа материалын зардал	2,096.1
210401	Бичиг хэрэг	96.1
210402	Тээвэр, шатахуун	2,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	
210404	Ном хэвлэл авах зардал	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгах зардал	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500.0
210604	Урсгал засвар	1,500.0
2107	Томилолт, зочны зардал	267.2
210702	Дотоод албан томилолт	267.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	46.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	
210802	Аудитын үйлчилгээ	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	21.5
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,802.5
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,802.5
320001	Орон нутгийн төсвөөс	22,802.5
80835	Төрийн албан хаагчдад олгох мөнгөн тусламж	4,200.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,200.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,200.0
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,200.0
320001	Орон нутгийн төсвөөс	4,200.0
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	224,409.2
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	224,409.2
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	224,409.2
320001	Орон нутгийн төсвөөс	224,409.2

Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр
сарын 09 -ны өдрийн 4/05 тоот
захирамжийн хоёрдугаар хэвсрэлт

ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Цалингийн шатлал	Ажлын чиг үүрэг
1	Дарга	ТУ-11	Мандалговь хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд "хог хаягдлын тухай хууль", "эрүүл ахуйн тухай хууль", "барилгын тухай хууль" зэрэг бусад хууль тогтоомж аймаг, сумын ЭЗНАХҮЧТөлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, гудамж талбайн гэрэлтүүлэг, чимэглэл, хог хаягдлын тээвэрлэлт үйлчилгээ, авто болон явган зам, нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээны ажилд байнгын хяналт тавьж удирдлагаар хангах. Хотын захирагчийн энэ талаарх мэдээллээр хангах.
2	Инженер	ТУ-8	Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу гудамж талбайн гэрэлтүүлэг, бүтээн байгуулалт, ногоон байгууламж нэмэгдүүлэх, засвар үйлчилгээ хийх талаар шийдвэр гаргахад санал оруулах. Эрхэлсэн асуудлын хүрээнд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэлт, бохир усны үйлчилгээнд хяналт тавьж үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангах. Авто болон явган замын цэвэрлэгээ үйлчилгээ, хог хаягдлын тээвэрлэлт, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах талаар газрын дарга, хотын захирагчийг мэдээллээр хангах.
3	Нягтлан бодогч	ТУ-8	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн үйл ажиллагааг явуулж, байгууллагын төсвийг үнэн бодитой төлөвлөх, зөв зарцуулах, өр авлагагүй ажиллах, хөрөнгө материалыг эмхлэн цэгцлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, санхүүгийн үнэн зөв мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

